Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.ЭНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: НЭГ. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, бодлого, шийдвэр , үндэсний болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах. | Хөтөлбөр хэрэгжсэн байна | 2 дэд хөтөлбөр хяналтанд авах | Шинээр гарсан шийдвэр, хөтөлбөрүүдийг бүртгэж авсан байна | Аймгийн дэд хөтөлбөрүүд “Нэг өрх нэг ажлын байр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөрүүдийг хяналтад авч хувийн хэрэг хөтлөн баяжилтуудыг хийсэн . “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөр шинэчлэгдэн батлагдаж, 2024 он хүртэл хугацаа нь сунгагдсан . Сумын “Хүнсний эрхийн бичгийн” үйлчилгээнд хамрагддаг өрхийн 30 хувийг буюу 21 өрхийн амьжиргааны түвшинг ахиулах зорилгын хүрээнд дэлгэрэнгүй судалгаа авч өрхүүдэд төлөвлөгөөний дагуу сургалтуудыг хийж нийт 24 иргэн | 2024.01.02-2024.12.31 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан. Нийт өрхөд байгаа хөдөлмөрийн насны иргэдэд 2 удаа сургалт хийж төсөл хөтөлбөрт хамрагдах боломжуудын талаар мэдээлэл өгсөн. Мөн өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 2 эмэгтэйн төслийг ХХҮГазарт дамжуулан аж ахуй эрхлэх хөтөлбөрт хамруулаад байна. Нийт 6 сая төгрөг санхүүжилт авсан. | | |
| 2. | Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах. | Зөвлөн туслах үйлчилгээ | 120 иргэн | 150 иргэн | 2024 онд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" үндэсний зөвлөлөөс баталсан 5 хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх тэдний бий болгосон ажлын байрыг тогтовортой авч үлдэх санхүүжилт хүссэн иргэдэд хэрхэн хөтөлбөрт хамрагдах талаар мэдээлэлээр хангаж зөвлөн туслах үйлчилгээг 171 иргэнд өгч ажиллаа. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| 3. | Нийтийг хамарсан ажил хийх төсөл боловсруулан холбогдох байгууллагаас дэмжлэг авч, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх тус ажилд бүртгэлтэй ажилгүйчүүдийг хамруулж, түр ажлын байраар хангах, тайлагнах | Нийтийг хамарсан ажлын төслийг боловсруулан санхүүгийн дэмжлэг авах | 45 ажилгүй иргэн | 40 ажилгүй иргэн түр ажлын байраар хангах | Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод бут тарих, нөхөн тарилт хийх ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг тус оны 5-р сарын 16-ны өдрөөс 31-ний өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд 10 ажилгүй иргэн 1 өдрийн 40000 төгрөгийн цалинтай ажилласан. ХЭДСангаас 4000000 төгрөгийн санхүүжилтээр иргэдийн цалинг шийдвэрлэн ажиллуулаа. 10 иргэн түр ажлын байраар хангагдсан. Мөн 4 сард сэг зэм устгалын ажилд ажилгүй | 2024.01.02-2024.12.31 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ХЭДСангаас санхүүжилтийг нь шийдвэрлэсэн байна. Мөн 7 сард ойн арга хэмжээтэй холбоотойгоор 13 иргэнийг түр ажлын байраар хангаж 5.2 сая төгрөг цалинд зарцуулав. | | |
| 4. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажилд авч тогтвортой ажиллуулсан тохиолдолд тухайн байгууллагад хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих. | 1 аж ахуй нэгж | 1 аж ахуй нэгж | 12 сард 1 аж ахуй нэгж | Аж ахуйн нэгжүүдэд ажлын байрны урамшууллын тухай журмыг сурталчилан гарын авлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг болох зорилгоор аж ахуй нэгжүүдийн захиалгаар хэрэгцээтэй нэн шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэж хамтран ажиллаа. Аж ахуй нэгжийн захиалгаар 12 иргэн тогоочийн сургалтанд хамруулав. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж стандартыг аж ахуй нэгж, байгууллага, ажлын байранд мөрдүүлж хэвшүүлэх | Хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн аж ахуй нэгжийн тоогоор | 3 аж ахуй нэгж | 4 аж ахуй нэгж | ХАБЭА-н хууль тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор жил бүр 4 сарыг ХАБЭА хангах сар болгон зарласантай холбоотойгоор энэ жилийн хувьд хууль тогтоомжийг сурталчилан төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулан тайлан мэдээг холбогдох газар нь хүргүүлэн ажиллаа. Мөн ХАБЭА-н улсын үзлэгийг 11 сард зохион байгуулан нийт 7 аж ахуй нэгжийг хамруулан дүн мэдээг ХХҮГазарт явуулсан. | 2024.01.02-2024.12.31 | 100 |
| Зорилт 2: “ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙГ САЙЖРУУЛЖ , ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ажилгүй иргэдийн судалгааг гарган, бүртгүүлсэн хүн бүрт карт хөтөлж, мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийж хэвших. | Профайленгийн үйлчилгээг үзүүлсэн байна. | 30 иргэнд | 50 иргэн | Оны эхнээс нийт 50 иргэнд профайленгийн үйлчилгээ үзүүлсэн. Энэ нь ажилгүй, ажил олгоход хүндрэлтэй иргэний сэтгэл зүйн шинжилгээ хийх сорил бөгөөд нэг иргэн нийт 120 минут орчим ярилцлагын аргаар явагддаг тухайн иргэний хувь хүний хэрэгцээг тодорхойлох тест юм. | 2024.01.02-2024.12.31 | 100 |
| 2. | Ажилгүй иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлж тэдэнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, мэргэжлийн сургалтад хамруулах мэргэжилтэй болох. | Жилдээ 10-оос доошгүй иргэнийг мэргэжилтэй болгосон байна. | 10 иргэн | 10 иргэн | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 112 иргэнийг хамруулсан. Үүний 51 нь ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд, 61 бүлгийн сургалт болон танхимаар сургалтуудад хамрагдсан. Хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны иргэдийг ажиллах боломжоор хангах тэднийг хөдөлмөрт бэлтгэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 3 удаа зохион байсан. Мэргэжлийн сургалтад 20 иргэн хамруулж үнэмлэхтэй болгов. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| Зорилт 3: "ШИНЭЭР АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ " | | | | | | | |
| 1. | ХЭДСанийн дэмжлэгээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалах | Ажилтай болсон иргэдийн тоогоор | 10 иргэн | 40 иргэн | ХЭДсанийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн ажлын байрны дэлгэрэнгүй судалгааг гаргаж ХЭСДсангийн санхүүжилтээр нийт 10 шинэ ажлын байр, түр 33 ажлын байр бий болсон байна. | 2024.01.02-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Шинээр бий болсон ажлын байрны болон бусад мэдээллийг аж ахуй нэгж байгууллагаас цуглуулах, ажлын байрны захиалга авах зуучлах. | Бий болсон ажлын байрны тоогоор | 170 иргэн ажлын байртай болох<br><br>Зуучлалаар 80 | 180 иргэн | Орон нутагт хэрэгжүүлж байгаа томоон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн үр дүнд 149 ажлын байр бий болсон байна. 69 түр ажлын байр зуучлалаар бий болсон байна. Сумын хэмжээнд зуучлалаар 81 ажлын байр бий болсон. ХЭДСангийн санхүүжилтээр 15 малчин малжуулах хөтөлбөрт нийт 120.0 сая төгрөг, Аж ахуй эрхлэлтийн хөтөлбөрт 2 иргэн 12 сая, Ахмадын хөтөлбөрт 3 иргэн 13 сая, ХБИ хөтөлбөрт 2 иргэн 12 сая тус тус санхүүжилт олгосон байна. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| Зорилт 4: "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг чанд мөрдөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Томилогдсон ажлын хэсэг, авсан үүрэг даалгаврыг биелүүлэх | Томилогдсон ажлын хэсэг бүрт | Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж ёс зүйн зөрчил гаргаагүй. | 2024.01.02-2024.12.31 | 100 |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Стандартыг мөрдөж биелүүлсэн байна. | Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | Байнга | 2022 оны бичиг баримтыг үдэн цэгцэлж архивт хүлээлгэн өгсөн. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллаж байна. Архив бичиг хэргийн шинэчлэгдсэн журмыг өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. | 2024.01.02-2024.12.31 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

## НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | E-Mongolia цахим үйлчилгээний операторын үүргийг хүлээх | Сумын оператор | 200 иргэн | 350 иргэн | Операторын тоон гарын үсгийн гэрээг шинэчлэн сургалтад танхимаар нэг удаа хамрагдсан ба программын шинэчлэлийг бүрэн хийлгэсэн. Мөн цахим шинэчлэл болон цахим халдлагаас сэргийлэх цахим сургалтад нэг удаа тус тус хамрагдлаа. 453 үйлчилгээний 220 гаруй нь иргэнд лавлагаа мэдээлэл гарган үйлчиллээ. | 2024.01.02-2024.12.31 | 100 |
| 2 | Хүүхдийг ивээх сангийн Хужирт суманд хэрэгжиж буй нэгжийн гишүүнээр ажиллах | Зөвлөлийн гишүүн | 8 төсөл | 10 төсөл | Японы хүүхдийг ивээх сангийн төслийн сумын зөвлөлийн гишүүний ажлыг давхар хийж байгаа ба 2 удаа сургалтанд хамрагдаж мөн ЕБСургуулийн хүүхдүүдийн дунд зохиогддог 'PITCH EVENT' арга хэмжээнд 1 удаа оролцсон байна. | 2024.01.02-2024.12.31 | 100 |
| 3 | Хуулийн хүрээнд холбогдох ажлын хэсэгт орж ажиллах | Сонгуулийн хэсгийн хороо | 2 | 2 | Монгол улсын их хурлын ээлжит сонгуулийн хэсгийн хороо, Аймаг, нийслэл,сум дүүргийн ИТХурлын төлөөлөгчдийн ээлжит сонгуулийн хэсгийн хороодод орж ажиллаа. | 2024.01.02-2024.12.31 | 100 |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны зөвлөлийн сургалтууд болон цахим сургалтад хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Шинэ гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллана | 2 сургалт | 2 сургалт | Өөрөө бие даан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. ХХҮГазараас зохион байгуулсан төрийн албаны шинэчлэл хуулийн сургалтад танхимаар 3 удаа хамрагдсан. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| 2 | Мэдээллийн технологи болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвараа дээшлүүлж өөрийн мэдлэг чавдараа тасралтгүй хөгжүүлж, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцах | Мэдээлэл технологи болон ур чадвараа ахиулсан байх | 1 сургалт | 3 удаа сургалтуудад хамрагдсан. | Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа боломжийг ашиглан орчин үеийн мэдээллийн технологийн аргад суралцаж, ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. Цахим орчны халдлагаас сэргийлэх сургалтад 1 удаа хамрагдсан. | 2024.01.02-2024.12.31 | 90 |
| 3 | Үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | Сургалтанд хамрагдаж мэдлэгээ гүнзгийрүүлэх | 1 удаа сургалт | 1 сургалт | "Хүмүүн бичиг" сонин захиалан уншиж, бичих чадвараа дээшлүүлсэн. Монгол бичгийг бие даан ахисан түвшиний сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан. Монгол бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай болсон. | 2024.01.02-2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ……[signature]…… Т. ЭНХЖАРГАЛ ……2024.12.30……

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )